

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 оны ...дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ШҮҮГЧИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.5 дахь хэсгийн “Түүнчлэн энэ тухай Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж гарсан бол заавал хэлэлцэнэ.” гэсэн хоёр дахь өгүүлбэрийг хассугай.

**2 дугаар зүйл.** Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.8 дахь заалт, мөн зүйлийн 17.4 дэх хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ГАРЫН ҮСЭГ

*Төсөл*

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2020 оны ...дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

**ПРОКУРОРЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ  
ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Прокурорын тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.6.4 дэх заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

ГАРЫН ҮСЭГ

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2020 оны ...дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

**АВЛИГЫН ЭСРЭГ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ  
ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Авлигын эсрэг хуулийн 22 дугаар зүйлийн 22.4 дэх хэсгийн “санал, эсхүл Монгол Улсын Ерөнхийлөгч Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмжийг” гэснийг “саналыг” гэж өөрчилсүгэй.

ГАРЫН ҮСЭГ